



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүн,
ажиллах журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар “Буянт-Ухаа спортын ордон” ТӨААТҮГ-т их засвар үйлчилгээг хэрэгжүүлэх Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Төслийн удирдах хорооны ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төслийн удирдах хорооны үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам” болон холбогдох бусад хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Төслийн удирдах хорооны дарга, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга /Ц.Баяр-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132003214

ТӨБЗГ тушаал-/2022

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 05 дугаар
сарын 16-ны өдрийн А/39 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүн

Удирдах хорооны дарга: Ц.Баяр-Эрдэнэ ТӨБЗГ-ын Төрийн өмчийн удирдлага,
зохицуулалтын хэлтсийн дарга

Гишүүд: Ч.Чимэдсор Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт,
хөрөнгө оруулалтын газрын дарга

Б.Баярбаатар Барилга, барилгын материалын
үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын ахлах мэргэжилтэн

Э.Бадамсүрэн Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн
захиргааны удирдлагын газрын
ахлах шинжээч

Э.Адьяасүрэн Биеийн тамир, спортын Улсын хорооны
санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Н.Баатаргэрэл Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын
захиргаа, санхүү, албаны дарга

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 05 дугаар
сарын 16-ны өдрийн А/39 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

“БУЯНТ-УХАА СПОРТЫН ОРДОН”-НЫ ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ, АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг: Зорилго

1.1 Гэрээ, хэлэлцээрт тусгасан төслийн бүрэлдэхүүн бүрийг стратегийн удирдлагаар хангах;

1.2 Төслийн үйл ажиллагааг Үндэсний бодлого, стратегитай нийцэж буй эсэхэд хяналт тавих;

Хоёр: Удирдах хорооны чиг үүрэг

2.1 Гэрээ, хэлэлцээрт тусгасан төслийн зорилтыг тогтсон хугацаанд бүрэн хэрэгжүүлэх зорилгоор төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон ТХНэгжийг /цаашид “ТХН” гэнэ/ шаардлагатай бодлогын удирдамжаар хангах;

2.2 Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй, үр ашигтай байлгах үүднээс тухайн салбар болон салбар хоорондын уялдаа холбоог хангах;

2.3 Төсөл, арга хэмжээний үйл ажиллагааны тухайн жилийн нарийвчилсан төлөвлөгөө, түүнд үндэслэсэн худалдан авах ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

2.4 Гэрээ, хэлэлцээр, батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу төслийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөний хэрэгжилт болон хяналт-шинжилгээний тайланг хагас жил тутам, төслийн явцын үнэлгээний жилийн тайланг дараа жилийн эхний улирлын хурлаараа хэлэлцэн дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээ авах талаар төсөл хэрэгжүүлэгч байгууллага, ТХН-д зөвлөмж хүргүүлэх, биелэлтэд хяналт тавих;

2.5 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллах, үр дүнг хариуцах, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ТХН-ийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар ТУХ /төслийн удирдах хороо цаашид “ТУХ” гэнэ/-д тайлагнах;

Гурав: Үйл ажиллагаа

3.1 ТУХ-ны бүрэлдэхүүнд төслийн захирал болон гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайн төслийн хэрэгжилтийн асуудал хариуцсан нэгжийн төлөөллийг заавал оролцуулна. ТУХ-ны бүрэлдэхүүнд тухайн төслийн онцлогоос хамааран холбогдох бусад албан тушаалтныг оролцуулж болно.

3.2 Тухайн төслийн зохицуулагч “Буянт-Ухаа спортын ордон” ТӨААТҮГ-ын захирал байна.

3.4 ТУХ нь төсөл, арга хэмжээний үйл ажиллагааны дунд хугацааны төлөвлөгөө, тухайн жилийн нарийвчилсан төлөвлөгөө, түүнд үндэслэсэн худалдан авах ажиллагааны

болон санхүүгийн төлөвлөгөөг хэлэлцэн батлах. төлөвлөгөөний хэрэгжилт болон хяналт-шинжилгээний тайланг хагас жил тутам, төслийн явцын үнэлгээний жилийн тайланг дараа жилийн эхний улирлын хурлаараа хэлэлцэн дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээ авах талаар төсөл хэрэгжүүлэгч байгууллага, ТХН-д зөвлөмж хүргүүлэх, биелэлтэд хяналт тавих, зөвлөмжийн биелэлтийг хангалтгүй гэж үзвэл холбогдох этгээдэд хариуцлага тооцуулах тухай саналыг хариуцлагатай байх зарчмын дагуу төсөл хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлэх зэрэг асуудлуудыг хэлэлцэхээр тогтсон хугацаанд, бусад асуудлаар шаардлагатай тохиолдолд тухай бүр хуралдана.

3.5 ТУХ-ны хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, танилцуулга, холбогдох бусад баримт бичиг, шийдвэрийн төслийг ТУХ-ны гишүүдэд ажлын 3 хоногийн өмнө хүргүүлсэн байна.

3.6 ТУХ-ны хуралдаанд гишүүдийн 60-аас доошгүй хувь оролцсон тохиолдолд ирц бүрдсэн гэж үзэх бөгөөд асуудлыг хуралд оролцож байгаа гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

3.7 ТУХ-ны гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд төлөөлөө томилон оролцуулж болох бөгөөд хуралдаанаас өмнө саналаа бичгээр өгсөн тохиолдолд түүнийг хурлын ирцэд оролцсоноор бүртгэнэ.

3.8 Шаардлагатай тохиолдолд хандивлагчид болон техник туслалцааны агентлагуудын төлөөллийг ажиглагчаар урьж оролцуулж болно.

3.9 ТУХ тогтоол гаргана.

3.10 Бичиг баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивт нарийн бичгийн дарга хүлээлгэж өгнө.